



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 08 сарын 05 өдөр

Дугаар 4/04

Мандалговь

Г

Сургалт явуулах тухай

Г

Монгол Улсын "Цэргийн албаны тухай хууль"-ийн 33 дугаар зүйл, "Дайчилгааны тухай хууль"-ийн 29 дүгээр зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 230 дугаар тогтоол, Батлан хамгаалахын сайдын 2018 оны н/01, ЗХЖШ-ын 2018 оны н/40 албан тоот, Батлан хамгаалахын сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 1.5 дугаар зүйлүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Цэргийн штабын "Сургалтын нэгдсэн төлөвлөгөө"-нд тусгагдсаны дагуу ДБНБ-ний I зэргийн бэлтгэл үүрэгтэн 30 хүн, II зэргийн бэлтгэл үүрэгтэн 60 хүн нийт 90 хүний сургалтыг 14 хоногийн хугацаатайгаар Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн сургалтын төвийн материаллаг баазыг түшиглэн 2018 оны 3, 4, 5 дугаар саруудад тус бүр явуулсугай.

Хоёр. Батлан хамгаалах яамнаас аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн сургалтын зардал 10.388.000 /арван сая гурван зуун наян найман мянга/ төгрөгийг гарган зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Д.Нандинцэцэг/ нарт зөвшөөрсүгэй.

Гурав. Дээрх ДБНБ-ний нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн байлдагч, түрүүчийн, II зэргийн бэлтгэл үүрэгтэний сургалтыг төлөвлөгдсөн хугацаанд чанартай, осол авааргүй явуулахыг Цэргийн штабын дарга, хурандаа Б.Амаржаргалд даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200256